



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

┌ Үнэт цаас бүртгэлээс хасах тухай ┐

Компанийн тухай хуулийн 83.1 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 271 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8.10.11-р заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Бүртгэлийн журам”-ын 23.6, 23.9-р заалт, “Өгөөмөр Уул” хувьцаат компанийн 2014 оны 08-р сарын 15-ны өдрийн 018/14 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайлан 2014 оны 09-р сарын 04-ний өдрийн захирлын зөвлөлийн хурлын санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өгөөмөр Уул” хувьцаат компанийн гаргасан нийт 57,835 /тавин долоон мянга найман зуун гучин тав/ ширхэг хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн бүртгэлээс хассугай.
2. Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, “Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанид хадгаламжаас хасах мэдэгдэл хүргүүлэхийг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.
3. “Өгөөмөр Уул” хувьцаат компани зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж хязгаарлагдмал хариуцлагатай компани болж, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн бүртгэлээс хасагдсан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО,
ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ**

Хэнд: “Үнэт цаасны төлбөр тооцоо,
төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д

№ 288

Огноо: 2014.09.04

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ	
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаас бүртгэлээс хасах тухай	
Үндэслэл:	Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 271 тоот тогтоол, МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 09-р сарын 04-ны өдрийн № 188 тоот тушаал	
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Хувьцаа	
Үнэт цаасны нэр:	“Өгөөмөр Уул” ХК	
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/	OZM	
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/	Энгийн	
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус	
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/	57,835	
Энгийн	тоо /ширхэг/	57,835
	хувь %/	100%
Олон нийтийн Эзэмшил	тоо /ширхэг/	57,835
	хувь %/	100%
Төрийн эзэмшил	тоо /ширхэг/	-
	хувь %/	-
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100	
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	5,783,500	

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР